



ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 05 сарын 16 өдөр

Дугаар A/272

Хэрлэн сум

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн
эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын
салбар комиссын бүрэлдэхүүнийг шинэчлэн
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 66.3, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухайн 42 дугаар зүйлийн 42.1.1 дэх заалт, Засгийн газрын 2021 оны 173 дугаар тогтоолоор батлагдсан Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын комиссын дүрмийн 2.5 дахь заалтыг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ** нь:

1. Аймгийн хэмжээнд 0-18 насны хүүхдийг хөгжлийн бэрхшээлтэй эсэхийг тогтоох, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын үйлчилгээнд хамруулах үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, хэрэгжилтэд хяналт тавих зорилго бүхий салбар комиссын дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Дарга	Аймгийн засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга
Нарийн бичгийн Дарга	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын Хөгжлийн бэрхшээлтэй иргэний асуудал хариуцсан мэргэжилтэн
Гишүүд	Боловсрол, шинжлэх ухааны газрын хүүхдийн хөгжил хамгаалал, тэгш хамран сургах боловсрол хариуцсан мэргэжилтэн
	Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын газрын Хүүхдийн эрх хамгааллын асуудал хариуцсан ажилтан
	Нэгдсэн эмнэлгийн Хүүхдийн их эмч
	Нэгдсэн эмнэлгийн Мэдэрлийн их эмч
	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхчүүдийн холбооны тэргүүн

2. Салбар комиссын үйл ажиллагааг тогтолжуулах, чиг үүргийг хэрэгжүүлж ажиллахыг комиссын даргад үүрэг болгосугай.

2.

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2022 оны А/96 дугаар захирамжийг хүчингүйд тооцсугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Гантулга)-д уүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Ц.ЧОГСОМЖАВ

